

## МОНГОЛЧ ЭРДЭМТЭН ЧАРЛЬЗ БАУДЕН

Л.Чулуунбаатар<sup>1</sup>

Цаг цагаараа байдаггүй цахилдаг хөхөөрөө байдаггүй хэмээх үг нь ертөнцийн юмс үзэгдэл бүгд хувирч өөрчлөгддөг, хуучин юм ул болж, шинэ юм зул болно гэх мэтийн олон утгыг агуулдаг байна. 30 жил өнгөрөхөд энэхүү үг үнэн болохыг нүдээр үзэж биеэр мэдрэв. Америкийн монголч эрдэмтэн Роберт Рупин “XX зууны Монголчууд”(1964) хэмээх ном бичиж хувьсгалт түүхэнд харш монголын түүхийн маш олон үнэн бодит баримт оруулж, үнэнийг бичсэний учир хийгээд Английн монголч эрдэмтэн Чарльз Бауден “Монголын шинэ түүх”(1968) хэмээх бүтээл туурвиж “Монголчууд хэдэн өндөр цагаан байшин босгосноо социализм байгуулж байна хэмээн хий хөөрцөглөж байна” хэмээн дүгнэснийх нь төлөө тэртээ 70, 80-аад онд хөрөнгөтний харгис эрдэмтэд хэмээн цоллож үзэл суртлын хурц зэвсгээр шүүмжилдэг байсан билээ. Америкийн монголч эрдэмтэн Роберт Рупины “XX зууны Монголчууд” хэмээх ном нь нэрт дуун хөрвүүлэгч Г.Аким авгайн хичээл зүтгэлээр 2000 онд монгол хэлнээ хөрвүүлэгдэн монгол уншигчдын хүртээл болж, нээлтэн дээр нь өвгөн эрдэмтэн хүрэлцэн ирж баярын нулимас унагаж байсан билээ.

2007 оны 5-р сард Монгол улсын ерөнхийлөгч Н.Энхбаяр Англи улсад албан ёсны айлчлал хийж монголч эрдэмтэн профессор Чарльз Бауден, Алан Сандерс, Жүдит Нордбай нарыг монгол судлалын салбарт жинтэй бүтээлүүд туурвисных нь төлөө алтан гадас одонгоор энгэрий нь мялаав. Тийм болохоор л цаг цагаараа байдаггүй цахилдаг хөхөөрөө байдаггүй хэмээх үг санаанд орж ирсэн билээ. Олон улсын монголч эрдэмтдийн анхдугаар хурлын төлөөлөгч, монгол судлалын гарамгай эрдэмтэн, профессор Чарльз Бауден гуайтай хоёр жил хамт ажиллаж, ярьж хөөрч явсны хувьд монгол судлалын нэрт эрдэмтэн энэ хүний тухай өөрийн дурсамжаа бичих нь зүйтэй хэмээн шийдэв. 1989-1991 оны хооронд Лондонгийн Их Сургуульд зочин багшаар уригдан очоод ажиллаж байх цагт Профессор Чарльз Бауден гуай хэдийгээр тэтгэвэртээ гарсан ч 1963 оноос эхэлж 34 жилийн тэсвэр тэвчээр, мэдлэг оюун, шургуу хөдөлмөр зарсан “Монгол Англи толь”-ио ид хийж байсан билээ. Намайг очиход ерөнхийдөө толио дууссан боловч 1980-аад онд гарсан ил тод байдлын дэвшилтэт нөлөөгөөр монгол ёс заншил сэргэн, монгол хэлний үгсийн санд мартагдах шахсан олон хуучирсан үг шинээр орж ирэн тэр бүхнийг толиндоо нэмж тусган оруулахын тулд зөв ухаарч ойлгох хэрэгтэй болоод байсан хэрэг юм. Бид хоёр, долоо хоногт хоёр удаа 90 минутаар хичээллэдэг байв. Ч.Бауден гуай үгээ авчирч би түүний нь монголоор тайлбарлан, дахин дахин ярилцаж сайн ойлгосны дараа дараагийн үгэндээ ордог байв. Түүний нас 70 руу хэвийж байсан болохоор тэр юмуу хичээл дуусахын алдад “за одоо миний

<sup>1</sup> Доктор, дэд профессор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

толгой хүлээж авахаа байлаа, хоёулаа хоолонд оръё” гэдэгсэн. Тэгээд ч бид хоёрын хичээл дуусахад үдийн хоолны цаг таардаг байсан болохоор энэ үгийг хэлдэг байсан биз. Энэ удаа Бауден гуай даасан бол дараагийн удаа би даах журмаар хоолны үнээ харилцан төлдөг байж билээ. Дэлхийн олон орны их дээд сургууль үдийн хоолны цаг гэж байдаг бол манай Монгол улсын их дээд сургуулиуд үдийн хоолны цаг гаргадаггүй нь багш оюутны эрүүл мэндэд алсдаа муугаар нөлөөлөх хор уршигтай болой.

Чарльз Бауден гуайд энэ толио бүтээх санаа Боннын Их Сургуулийн багш Магадбүрэн Халтодыг 1963 онд Лондонгийн Их Сургуулийн Ойрх дорнот болон Африкийн судлалын сургуульд 3 сарын хугацаагаар ажиллахаар ирээд байх үед нь төрсөн байна. “Үг олдож үхэр холдлоо” хэмээн Магадбүрэн гуай их хэлдэг байсан хэмээн хуучилдаг байв. Монгол-Англи толь хийхийн тулд БНМАУ-ын орчин үеийн хэлний үгийг хамтдаа цуглуулахаар ярьж тохиролцсон байна. ОДАСС (SOAS) кирил үсэгтэй 2 бичгийн машин болон бичгийн хэрэгсэл зэрэг боломжийн хандив дусламжийг үзүүлсэн байдаг. Цуглуулсан үгнүүдээ шуудангаар харилцан илгээж, шалгаж нягтлан нэгтгэж нийлүүлэх бодолтой байжээ. Хоёр тусдаа хол газар ингэж ажиллах нь үнэн хэрэгтээ тэдний бодсоноос ихээхэн бэрхшээлтэй байсан ч үргэлжлүүлсээр байсан гэдэг. 1978 оны 8-р сард Магадбүрэн гуай гэнэт таалал төгссөнөөр хамтран ажиллах бололцоо дуусгавар болжээ. Тэрээр “Би түүний аугаа их судлаачийн байр сууринд хүрэхгүй боловч толио дуусгахыг амьдралын зорилго болгосон” хэмээн хуучилдаг байсан билээ. Энэ тухайгаа ч толийнхоо оршилд дурдсан бөгөөд энэ ажилд хөтлөн зоригжуулсан Магадбүрэн гуайд талархал илэрхийлээд, мөн 1963-1964 онд ОДАСС-д нэг жилийг өнгөрөөсөн Цэцэн Жагчид болон хожим 1967-1968 онд Улаанбаатар хотод байхдаа Ж.Цолоо, Э.Вандуй нараас их зүйл сурсан хэмээгээд тэдэнд талархалаа илэрхийлсэн байдаг юм. Мөн “МУИС-иас ОДАСС-д ирж ажиллаж байсан багш Л.Чулуунбаатарт гүн талархлаа илэрхийлэх өртэй бөгөөд бараг 2 жилийн турш өгөөмөр их тус хүргэж, миний асуултад хариулж бэрхшээлийг минь арилгахыг хичээж байсан билээ. Эцэст нь түүний дараа ирсэн Ж.Бат-Ирээдүй багшаас ч бас өгөөмөр их туслалцааг энэ ажилдаа авсан билээ” хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг. Толийнхоо оршилд дурдаагүй боловч хууч хөөрөхдөө С.Нямсүрэн багш толийг минь уншиж засч их тусалж байсан хэмээн дурддаг байсан билээ. Толио бүтээхдээ урьд өмнө гарсан толиудыг шүүрдэж үзэхийн хамт Монгол улсад гарсан сонин сэтгүүл, шинжлэх ухааны төрөл бүрийн салбарын ном хэвлэлийг уйгагүй шүүрдэн уншиж үгийг карталж тэдгээрийн утгыг тодорхой нарийн харгуулах, дүйцэх үгийг олохын төлөө цаг зав хайрлахгүй маш шургуу, хичээнгүй ажилласны ул мөр болж энэ толийн үйл үгийн оноолт хийгээд монгол англи үгийн оноолт маш сайн болсон байдаг. Түүний тулд л бидний хичээлийн үед нэг үгийн нарийн сайн ойлготлоо дахин дахин асууж тайлбарлуулж яриулдаг байсан билээ.

Аугаа хөдөлмөрч энэ хүн 1924 оны 4-р сарын 22-ны өдөр дулаан зөөлөн уур амьсгалт, Английн өмнөт эргийн хот болох Веймоут (Weymouth) хотод Чарльз Роскеллийнхний гэр бүлд хоёр дахь хүү нь болон төржээ. Аав, ээж хоёр нь хоёулаа дунд сургуулийн багш байсан болохоор хоёр хүүгээ эрдэм номтой, хүний дайтай хүн болгон өсгөжээ. Тийм болохоор Ч.Бауден Лондонгийн Их Сургуулийн монгол судлалын гавьяат профессор, Британийн Академийн жинхэнэ гишүүн, дэлхийд нэртэй монгол судлалын эрдэмтэн, ах нь далайн цэргийн нэр хүндтэй офицер, инженер хүн болсон байна. Ч.Бауден дэлхийн II дайны гал ид дүрэлзсэн 1943-1946 оны хооронд 3 жил Британийн усан цэрэгт алба хаажээ. Дараа нь Кембрижийн Их Сургуульд орж суралцан төгсгөөд, 1955 онд “Алтан товчийн цаг тооллын бичиг” сэдвээр докторын

зэрэг хамгаалжээ. 1950-иад оны эхээр монгол бичгийн хэлээр монгол хэл сурсан болохоор 1955 оноос сонгодог монгол бичгийг сонгох хичээл маягаар зааж эхэлжээ. Лондоны Их Сургуульд багшаас эхлэн салбар сургуулийн захирал, проректорын алба хүртэл хашиж явсан тэрбээр дэлхийн монгол судлалд нэр алдраа дуурсгасан олон бүтээл хэвлүүлсний дотор монголын эртний уран зохиол, хуучин сурвалж эх бичгээр дагнан ажиллаж “Алтан товч”(1956), “Бигирмижид хаан ба шинэхэн түүх” (1968), “Хүрээний Жавзандамба хутагт”(1962), “Монголын шинэ түүх”(1969, 1989), “Монгол-Англи толь”(1997), “Монголын уламжлалт утга зохиолын дээжис” (2003) зэрэг ном, “Монголын Боржгин овгийн түүх”, “Монголын эрт ба одоо”(1959), “Сүнс дуудах тухай”(1962) зэрэг эрдэм шинжилгээний алдартай өгүүллүүдээ хэвлүүлжээ. Тэрээр монгол судлалын нэрт эрдэмтэд Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Ш.Нацагдорж, Х.Пэрлээ, Г.Сэр-Оджав, О.Намнандорж, Ц.Дорж, Я.Цэвэл гуайтай танилцаж, уулзаж хуучилж явжээ. Б.Ринчен багштай 1954 онд анх захидлаар холбоо тогтоосон болохоор миний анхны багш нарын нэг хэмээн хэлдэг байсан. Б.Ринчен багшаас хүлээн авсан 12 захидал болон ил захидал байдаг бөгөөд нэг удаа тэдгээрээ надад авчирч үзүүлсэн билээ.

Б.Ринчен багш 1954 онд анхны хариу захиагаа францаар бичиж ирүүлсэн байв. Ч.Бауден гуай түүнийг надад *“Би таны захидалыг хүлээн авсан. Мөн Пенти Алто тантай уулзсанаа бичсэн байсан. Түүндээ таныг “Алтан товч”-ийн талаар ажил хийж байна хэмээн бичсэн байсан. Англи улсад монголын тухай судалдаг монголч эрдэмтэн байгаад би баярлаж байна. Та надад франц, орос, герман, англи хэлээр захиа явуулж болно. Миний бие хэл шинжлэлч, угсаатны зүйч, зохиолч, орчуулагч эрдэмтэн хүн билээ. Танай эх хэлнээс Шекспирийн Отеллог орчуулсан. Үүнээс гадна Жек Лондон, Сетен Томсоны зарим өгүүллэг орчуулсан. Лувсанданзаны “Алтан товч”-ийн Улаанбаатарт хэвлэгдсэн эх нь шинжлэх ухааны ном биш. Тэгэхлээр Мостерт гуайн нийтлүүлсэн хувилбар нь Улаанбаатарт хэвлэгдсэн номоос шууд авсан учир үнэ цэнэ муутай байна. Та яагаад “Алтан товч”-ийг орчуулж байна. Энэ зохиолыг өмнө Галсангомбоев орос хэлээр орчуулж гаргасан. Дахиад орчуулах хэрэггүй. Манай соёлын олон үнэт ном орчуулагдаагүй байна. Та түүнээс орчуулж болно”* хэмээн монголоор орчуулж өгөөд мөн тэрээр захидлын төгсгөлд монгол бичгээр шинэ он ойртож байгаа учир шинэ жилийн амар айлтгаж, төвд судлаачийн тухай сонирхон асуусаныг сонирхуулж билээ. Энэ захиаг ийнхүү орчуулан хэлж өгөөд “Тэр үед Лондонгийн Их Сургуулийн номын санд монгол бичгээр “Алтан товч”-оос өөр ямар ч ном байгаагүйг Ренчин багш мэдээгүй болохоороо л ингэж бичсэн байсан хэрэг” хэмээн нэмж тайлбарласан билээ. Мөн Ч.Бауден гуайд 1961 оны 4 сарын 27 нд Б.Ринчен өөрөө дурсгалын үг, гарын үсэг зурж өгсөн “Үүрийн туяа” роман байдаг юм билээ. Нэрт энэ эрдэмтэнтэй үлэмжийн дотно харьцаатай байсан учир таалал төгссөнийх нь дараа 1979 онд Кембрижед гардаг “Англи-Монголын сэтгүүл”-д “Академич Ринчен” хэмээх эмгэнэлийн том өгүүлэл бичиж “монгол судлалын нэгэн гарамгай од биднээс хагацан одлоо” хэмээн харамсан бичиж байсан билээ.

Энэхүү өгүүллийг би 1991 онд “Улаанбаатар” сонинд орчуулж гаргаснаа санаж байгаа бөгөөд Б.Ринчен багшийг таалал төгсөхөд монгол хэл, бичиг соёлынхоо төлөө цогтой тэмцэгч эх оронч, аугаа их энэ хүний тухай монголын ганцхан “Хөдөлмөр” сонинд товч эмгэнэлийн мэдээ гарч байсан билээ. 1967 оны 8 сараас 1968 оны 2-р сар хүртэл Монголд байхад нь Э.Вандуй, Ж.Цолоо нар монгол хэлний багш хийж байжээ. Ж.Цолоог залуухан 20 настай, эхнэртэй хийгээд багш болон хөтөч хийдэг байсан

хэмээн хуучилж байв. Ховд аймагт 2 долоо хоног зочилж замбаа идэн, тэмээний хоормог ууж, “Чоно харах” голоос загас барьж идсэн байна. Ховд хотод казак айлд зочилж, Манхан суманд очсон байна. Мянгад суманд олон туульчийн тууль бичиж авсанаасаа нэг явган үлгэр нийтлүүлжээ. Монгол улсад 5 удаа зочилж байсан бөгөөд эхний удаад Монголын энх тайвны хорооны урилгаар 1958 онд Лондонгоос Копенгаген, тэндээсээ Москва, тэгээд Эрхүү хүртэл онгоцоор, Эрхүүгээс Улаанбаатар ортол хоёр давхар далавчтай онгоцоор, 1920 онд монголд очиж байсан 75 настай Смоолвууд (Smallwood) хэмээх хүнтэй хамт очиж байжээ. Уран зураач Чогсом, Сэрээтэр нартай хамт зураг авахуулж, Налайхын уурхайд зочлон уурхайчидтай хамт зураг авахуулсан байна. Мөн Намнандорж, Роберт Рупин, Эрдэнэпил хамба, Пагва багш, Энх тайвны хорооны нарийн бичгийн дарга Загд нартай зургаа авахуулж байсан байна. Хоёрдахь удаа 1959 онд Монголч эрдэмтэдийн анхдугаар хуралд оролцохоор Зөвлөлтийн усан онгоцоор Ленинград хотод очоод, тэндээсээ Москва тэгээд Улаанбаатар хүртэл галт тэргээр хоёр долоо хоног аялж очиж байжээ. Энэ үедээ Ринчен багш, Чингэлтэй профессор, Инжинаш судлаач Эрдэнэтогтох нартай танилцаж, тэр гурвын зургийг авчээ. Гуравдахь удаад Монгол хэлний дадлага хийх, материал цуглуулахаар 1968 онд галт тэргээр Берлин, Варшав, Москвагаар дамжин Улаанбаатар орсон байна. Буцахдаа харин Унгарын Будапешт хотоор дайрч буцсан байна. Дөрөв, тавдахь удаа болох 1986, 1987 онд шууд нисэх онгоцоор Москвагаар дамжин Улаанбаатарт ирж байжээ. 1991 онд намайг буцахын өмнө “Жинхэнэ монголын амьдрал сэргэж маш сонин болж байна. Одоо би залуу болоосой” хэмээн байн байн өгүүлдэг байж билээ. Учир нь ардчилсан хувьсгал ялж, коммунист үзэл суртлын хүлээс алга болсон эрх чөлөөт, цэлмэг тэнгэрийн оронд дахин тааваараа зочлохыг хүсч байсан буй за.

## SUMMARY

The author reviews about life and works of Charles Bawden, a British scholar and famous Mongolist, who was invited to the First Conference on Mongolists.